

“МОНГОЛЫН ДУУ ХООЛОЙ” РАДИО СТАНЦЫН ХӨГЖЛИЙН ТҮҮХ, ҮЙЛ
АЖИЛЛАГААНЫ ӨНӨӨГИЙН БАЙДАЛД ХИЙСЭН АЖИГЛАЛТ

Г.Мэндхүү*

*МУИС-ийн Сэтгүүл зүй, олон нийтийн харилцааны тэнхимийн багш, доктор (Ph.D)

Түлхүүр үг: радио өргөн нэвтрүүлэг, “Монголын дуу хоолой” радио станц, гадаад сурталчилгаа, сонсогч

Мэдээллийг радио долгионы онцлогийг ашиглан үндэсний хил зэрэг бэрхшээлийг даван туулж, томоохон орон зайд дамжуулах явдал улс төрийн, эрх зүйн болон техникийн шинжтэй шийдвэрлэх шаардлагатай олон чухал асуудалтай холбоотой байжээ. Тиймээс олон улсын радио эфирийг бий болгох явдал энэ салбар дахь зайлшгүй зохицуулах шаардлагатай асуудлын нэг болж хувирсан юм. XX зууны хориод оны сүүл, гучаад оны эхэн үеэс дэлхийн хүчирхэг улс орнууд харь орны сонсогчдод зориулан тусгай радио нэвтрүүлэг бэлтгэж, дамжуулах оролдлого хийж эхэлсэн юм. Юуны түрүүнд гадаадын улс орнууд гадаадын сонсогчдод зориулсан радио нэвтрүүлэг дамжуулж эхэлсэн түүхийг товч өгүүлье.

АНУ гадаадын хүлээн авагчдад хандсан тодорхой чиглэсэн зорилго бүхий нэвтрүүлгийг 20-иод оны дунд үеэс явуулж эхэлжээ. 1924 онд Панамерикийн холбооны ивээл дор АНУ-аас Латин Америкт зориулсан нэвтрүүлгийг анх явуулсан түүхтэй юм. Гучаад оны дунд үеэс “Дэлхийн радио нэвтрүүлгийн сан”-гаас эрхлэн Амери-

кийн саятан Рокфеллерийн санхүүгийн дэмжлэгтэйгээр Европын сонсогчдод зориулсан радио нэвтрүүлгийг эхэлсэн бол, 1936 онд Америкт байгуулагдсан “Гадаад мэдээний алба” Латин Америкийн орнуудад Панамерикийн үзлийг дэлгэрүүлэх зорилготой радио нэвтрүүлгийг тогтмол явуулж эхэлсэн байдаг.¹

Олон улсын радио нэвтрүүлгийг анх санаачлагчдын нэг нь ЗХУ юм. 1927-1930 он хүртэлх гуравхан жилийн дотор Оросын радио гадаадын 58 хэлээр нэвтрүүлэг явуулдаг болсон байв. Баруун Европын орнуудын дотор юуны өмнө колоничлогч гүрнүүд колони орнуудтай байнгын харилцаа холбоо тогтоох хэрэгсэл болгох, өөрсдийн эзэмшилд байгаа орнуудад оршин суудаг европчуудыг цаг үеийн мэдээлэлээр хангах зорилгоор радиогийн гадаад нэвтрүүлгийг тогтмол зохион байгуулж эхэлжээ. Радио хүртээмжтэй, шуурхай шинжээрээ тогтмол хэвлэлээс ихээхэн давуу талтай байхын хамт Европын гүрнүүдийг колоничлох бодлогыг сурталчлах чухал суваг болж байжээ. Ийнхүү дэлхийн үзэл бодлыг өөрчлөх, нэг чигт болгох, өөрийн санаа бодлуудыг бусдад сурталчлан таниулах зорилгоор радио холбоог ихээхэн ашиглаж ирсэн туршлагатай. Дэлхийн хоёрдугаар дайны үед Европын эзлэн

түрэмгийлэгчид Африкт байгаа өөрсдийн эзэмшлийг хадгалан үлдэх зорилгоор тивийн хэд хэдэн оронд шинээр радиостанц байгуулснаар 40-өөд оны дунд үед 15 оронд радиостанц үйл ажиллагаа явуулж байжээ. Мөн ВВС-ийн харьяанд Гитлерийн эсрэг эвслийн орнуудын байлдааны үйл явцыг мэдээлэл, суртал нэвтрүүлгийн үйл ажиллагаагаар дэмжих зорилго бүхий Европын алба байгуулагдсан юм. Засгийн эрхэнд Нацистууд ирсний дараа Германд 1933 онд гадаад нэвтрүүлгийг англи, герман хэл дээр, 1934 онд испани, голланд хэл дээр явуулах болжээ. Фашист Итали 1933 онд Латин Америкт зориулсан нэвтрүүлгийг итали хэл дээр явуулах болж, 1935 онд Арабын орнууд дахь Их Британийн байр суурийг алдагдуулах зорилгоор араб хэлний нэвтрүүлгийн албыг байгуулжээ. Олон улсын эфирт, Гитлерийн эсрэг эвслийн орнуудын болон “Берлин-Ром-Токио” гэсэн тэнхлэгийн орнуудын радио нэвтрүүлгийн албадын хооронд нэлээд ширүүн тэмцэл өрнөж байсныг хэлэх хэрэгтэй. Энэ радио нэвтрүүлгийн гадаадын хүлээн авагчид болон эсрэг талын дайчдад суртал нэвтрүүлгийн, сэтгэл зүйн нөлөө үзүүлэх олон арга, хэлбэр бий болж, цаашид эрчимтэй баяжин хөгжсөн юм.² Японд олон улсын нэвтрүүлэг 1928 оны үеэс эрчимтэй эхэлсэн байна. Манжуур, Солонгос, Тайвань зэрэг колони орнуудын нутагт радио станц байгуулсны дараа НК гадаад нэвтрүүлгээ тогтмолжуулжээ. НК 1941 онд зөвхөн гадаад нэвтрүүлэг явуулах зориулалттай “Японы радио” хэмээх салбарыг байгуулсан бөгөөд уг салбар радио дэлхийн 16 улсын хэлээр нэвтрүүлгээ цацаж, Итали, Герман зэрэг улсуудтай холбоотны харилцаатай байж мэдээ материал солилцдог байжээ.

Олон улсын радиогийн хөгжлийн явцад зарим улс өөрийнхөө гадаад бодлогыг хэрэгжүүлэхийн тулд хил дамнасан нэвтрүүлгийг ашиглах оролдлого хийж байсан юм. Радиогийн хөтөлбөрийн объект болж буй улс орнууд гадаадын нэвтрүүлгийг тухайн орны дотоод хэрэгт оролцож, тусгаар тогтнолд нь халдсан явдал гэж үздэг нь түгээмэл байжээ. Тийм учраас үндэсний хүлээн авагчдад үзүүлэх гадаадын нэвтрүүлгийн нөлөөг аль болохоор хязгаарлах оролдлогыг хийх болжээ. 1930-1940-өөд оны үед зарим оронд гадаадын радиостанцуудын нэвтрүүлгийг сонсох боломжтой богино долгионы радио хүлээн авагчийг хориглож байсан юм.

Олон улсын радио станцуудын өөрийн орны сонсогчдод дамжуулах нэвтрүүлэг, гадаадын сонсогчдод дамжуулах нэвтрүүлэг хоёрын хооронд ялгаатай байдаг байна. Улс үндэстний нэршиж хэвшсэн зүйл, нэр томьёо, хэллэг гэх мэт зүйлсийг өөрийн орны сонсогчдод шууд хүргэдэг бол гадаадын сонсогчдод нэмэлт тайлбартайгаар хүргэдэг байна. Мөн шинжлэх ухаан, мэргэжлийн нэр томьёонуудыг хэрэглэхээс зайлсхийж, энгийн үгээр илэрхийлэхийг зорьдог. Сэдвийн хувьд улс орныг гадаадад сурталчлах чиглэлийн хүрээнд явагддаг бөгөөд үүн дотор:

- Түүх, соёл, урлаг
- Аялал жуулчлал
- Үндэсний брэнд бараа, бүтээгдэхүүн
- Спорт, олон улсын арга хэмжээ зэргийг түлхүү авч сурталчилдаг байна.

Улс үндэстний соёл гэдэг бол тухайн улсын имиж, өөртөө жуулчдыг татах нэгэн арга нөгөөтээгүүр соён гэгээрүүлэх арга зам юм. Соёлын үнэт зүйлсийн түгж тархах арга зам олон янз

байдгийн нэг хэсэг нь орчин үеийн техникийн гаралтай соёл иргэншлийн нөхцөл олон нийтийн мэдээллийн хэрэгсэл хэмээн нэрлэгдэх болсон сонин хэвлэл, радио, телевиз зэрэг зүйлс юм.³ Улс орны гадаад бодлогын нэг арга нь зөөлөн хүчний бодлого байдаг бөгөөд энэхүү бодлогын гол арга хэрэгсэл соёл юм. Соёлын гадаад зорилго нь олон улсын түвшинд улс орны цаашлаад ард иргэд, улс төр, эдийн засгийн бодлогын талаар эерэг дүр төрхийг бүрдүүлэх, түнш орнуудтай тогтоосон харилцаагаа бэхжүүлэх, болзошгүй зөрчил мөргөлдөөнөөс зайлсхийх зэргээр тодорхойлогдох бөгөөд урлаг, олон улсын үзэсгэлэн, солилцооны хөтөлбөр зэргээр дамжин илэрдэг. Олон улсын асуудлын талаар мэдээлэхдээ аль нэг улсын талд биш зөвхөн мэдээлэх үүргийнхээ дагуу төвийг сахисан байдлыг эрхэмлэдэг байна. Үүнээс гадна өөрийн орны ёс заншил, түүх, соёлыг сайшааж бусдыг нь үгүйсгэж, улс хоорондын харилцаанд сэв суух магадлалтай учир танин мэдүүлэх талаас нь мэдээлдэг бөгөөд гутаан доромжлох, шүүмжлэх асуудал байх ёсгүй байдаг. Аялал жуулчлалыг дэмжиж, жуулчдыг татах зорилгоор өөрийн орны үзэсгэлэнт, өвөрмөц газар нутаг, алдартай брэнд бүтээгдэхүүн, соёл урлагийг олон талаас нь таниулан мэдүүлдэг байна.

Гадаадад өөрийн улс орноо сурталчлан таниулах нь ямар ч төрт улсын нэг зорилго нэг гэдэг нь ойлгомжтой. Монголын радио энэ чухал зорилгыг биелүүлэхэд гол үүрэг гүйцэтгэх болсон байна. 1964 оны 6-р сарын 29-нд “Гадаадын сонсогчдод зориулан монгол хэлээр тусгай нэвтрүүлэг явуулж эхлэх тухай” Мэдээлэл, радиогийн улсын хорооны даргын 104-р тушаал гарч, “Улаанбаатараас ярьж

байна” гэдэг нэвтрүүлгийг долоо хоногийн пүрэв, ням гаригуудад 21 цагаас 30 минутын хугацаатай явуулж байхаар болжээ. Уг нэвтрүүлэг Хөх хотын чиглэлд монгол хэлээр, Бээжингийн чиглэлээр хятад хэлээр, Өрөмчийн чиглэлд казах хэлээр тус тус цацагдаж байв.

Дэлхийг олон орны сонсогчдод зориулан Монгол орныг сурталчлах гадаад хэлний нэвтрүүлгийн редакц МҮОНР-д 1964 онд “Монголын дуу хоолой” радио станц нэрээр байгуулагдсан юм. 1964 оны есдүгээр сарын 1-нээс монгол, хятад, орос, англи, франц, казах хэлний нэвтрүүлгүүд ээлж дараалан нээгдсэн түүхтэй. Монголын тухай мэдээлэл дэлхий нийтэд хомсхон байсан тухай цаг үед радиогийн гадаад нэвтрүүлэг анх цацагдсан тухайн цаг үед цацагдсан өдрөөсөө эхлэн дэлхийн олон орны сонсогчдын анхаарлыг татаж, захидал, хүсэлт тасралтгүй ирж эхэлсэн байна. Жишээ нь: 1965 оны эхний арван сард Энэтхэг, Австрали, Индонези, Япон, Канад, Америк, Мексик, зэрэг дэлхийн 20 гаруй орны 200 гаруй захидал ирсэн нь тухайн цагтаа томоохон үйл явдал болж, гадаад сурталчилгааг цаашид хөгжүүлэх нь зүйтэй гэдгийг нотолсон байна. Цаг хугацааны явцад хамгийн олон сонсогчтой монгол, орос, англи, хятад хэлний нэвтрүүлгүүдийг бэхжүүлж, япон сонсогчдын хүсэлтээр 1989 оны 1-р сараас Япон хэлээр нэвтрүүлэг бэлтгэн дамжуулж эхэлсэн юм. Монголын Радиогийн Гадаад нэвтрүүлгийн нэр хүнд, үр нөлөө жил ирэх тусам өсөж зарим жилд байнга захидал бичдэг сонсогчдын тоо 5000-д хүрч байлаа. Мөн Ази Номхон Далайн орнуудын Радио нэвтрүүлгийн холбоо 1972 онд гишүүнээрээ бүртгэн авсан юм.

1965 оны 1-р сарын 29-ний өдрөөс эхлэн Монголын радио Алс дорнод, Өмнөд ба өмнөд зүүн ази, Шинэ Зеланд, Австрали, Европын чиглэлд англи хэлээр нэвтрүүлэг дамжуулж эхэлсэн байна. Мөн онд радиогийн англи, хятад, монгол хэлний нэвтрүүлгийн редакцыг байгуулав. Баян-Өлгий аймгийн төвд Чехословак улсын тусламжаар баригдсан радио төв, холбооны техникийн барилгыг ашиглалтад өгсөнтэй холбогдуулж тус аймгийн хөдөлмөрчдөд төрөлх хэлээрээ радио сонсох боломж олгох зорилгоор радио нэвтрүүлгийн редакцыг байгуулсан байна.

1 1959 онд МОНЦАМЭ агентлаг, радио хороотой нэгдсэнээс хойш гадаад мэдээний хэлтэс “ Олон улсын байдлын тойм” нэвтрүүлэг бэлтгэж радиогоор ням гариг бүр тогтмол нэвтрүүлэг явуулдаг болсон юм. “Олон улсын байдлын тойм” нэвтрүүлэгт тэр үедээ өнгөрөгч долоо хоногт олон улсын хэмжээгээр болсон гол үйл явдлыг тоймлон тайлбарлаж байлаа. Энэ тойм нэвтрүүлэг, түүнчлэн тус хэлтсээс сүүлийн үед хийдэг болсон бусад нэвтрүүлэг нь олон нийтийн анхаарал татсан асуудлыг цаг тухайд нь гүнзгий ул үндэстэй нэгтгэн дүгнэж ямар шүү зорилго чиглэлтэй ямар үйл явдал хэрхэн өрнөсөн, олон улсын хэмжээнд үзүүлэх үр дагавар нь юу болох, коммунист ажилчны нам, социалист хамтын нөхөрлөлийн орнууд, түүний дотор манай нам, төр тэр асуудалд ямар бодлого баримталж байгааг манай хөдөлмөрчдөд тайлбарлан түргэн шуурхай хүргэхэд үр нөлөөгөө үзүүлж байв. Ийм ч учраас эдгээр нэвтрүүлгийг алгасалгүй сонсож, асууж лавладаг, мөн сонирхсон бусад асуудлаар яриулах хүсэлтээ ирүүлдэг сонсогчид хот хөдөөгүй олширч байв.⁴

1968 оны 5-р сарын 22-нд МАХН-ын төв хорооны улс төрийн товчооны 4-р тогтоолын дагуу Монголын радио 7 хоногт хятад хэлний нэвтрүүлэг 4 удаа явуулдаг байсныг өдөр бүр, монгол хэлний нэвтрүүлэг 4 удаа байсныг 6 удаа, казах хэлнийх 2 удаа байсныг 6 удаа, англи хэлнийх Ази, Африкийн хоёр чиглэлээр 8 удаа байсныг 12 удаа болгон тус тус нэмжээ. Энэ үед гадаад хэлний нэг нэвтрүүлгийн хугацаа 30 минут байсан юм. Уг тогтоолоор бас Франц хэлний нэвтрүүлгийг 7 хоногт 4 удаа шинээр явуулах, радиогийн гадаад хэлний редакцыг ерөнхий редакц болгох чиглэл өгсний дагуу 1968 оны 5-р сарын 23-ны өдөр БНМАУ-ын сайд нарын зөвлөлийн 169-р тогтоол гаргаж уг асуудлыг эцэслэн шийдвэрлэжээ. Харин Франц хэлний нэвтрүүлэг Төв болон Хойд Америк, Европ, Африкийн чиглэлээр 1970 оны 11-р сараас эхлэн явагдсан байна.⁵

1989 онд Монголын радио найрамдалт есөн орны радиогийн 30 орчим төлөөлөгчийг хүлээн авч, гадаад нэвтрүүлгийн үр нөлөө, арга барилын зөвлөгөөнийг анх удаа өөрийн оронд зохион байгуулсан байна. Мөн оноос Монголын радиогийн япон хэлний нэвтрүүлэг эхэлсэн бөгөөд уг нэвтрүүлгийн таван жилийн ойг тохиолдуулан Япон улсын засгийн газраас бэлэглэсэн 40 мянган америк долларын үнэ бүхий аппарат хэрэгсэл, тоног төхөөрөмжийг монгол улсад суугаа Япон улсын онц бөгөөд бүрэн эрхт элчин сайд Яширо Хасуми 1994 оны 5-р сарын 14-нд Монголын радиод хүлээлгэн өгсөн билээ.

1990 оны байдлаар Монголын радио гадаад сонсогчдод зориулан хоногт давталттайгаар 10 цагийн нэвтрүүлэг бэлтгэн эфирт гаргаж байна. Улаанбаатарын радиогийн олон хэлний

нэвтрүүлэг Ази, Номхон далайн бүс нутгийн орнуудын сонсогчдод голлон зориулагдаж гадаадын сонсогчдоос жилдээ дунджаар 1500 орчим захидал хүлээн авч байна. Гадаадаас хүлээн авч буй захидлын дотор ЗХУ, Хятад, Япон, Энэтхэг, Индонез, Англи, Хонг-конг, Сингапур, Өмнөд Солонгос, Ямайка, Бразилын сонсогчид ихэнх хувийг эзэлж байна. Монголын радио дэлхийн 60 гаруй оронд сонсогдож байна.⁶ Монголын радио 2000 оны байдлаар хоногт хоёр программаар 26 цагийн нэвтрүүлэг хийж байсны дотор орос, англи, франц, хятад, япон зэрэг хэлээр 10 орчим цагийн гадаад нэвтрүүлэг хийж байв. Радиогийн гадаад харилцаанд ихээхэн ахиц гарч Ази, Африк, Латин Америкийн 10 гаруй оронтой шинээр харилцаа, хамтын ажиллагаа хөгжүүлж эхэлсэн байна.⁷

2000 оны байдлаар Монголын радиогийн гадаад хэлний нэвтрүүлэг өдөр бүр 5 цаг эфирт гарч байсан бөгөөд япон, орос, хятад, англи, казах, монгол хэлнээ хөтөлбөр бэлтгэж байв. Гадаад хэлний нэвтрүүлэг богино долгионоор дамжуулдаг. Гадаад хэлний нэвтрүүлэг тус бүр 30 минутын хугацаатай боловч түүнийгээ гурав дахин нэвтрүүлнэ. Гадаад хэлний нэвтрүүлгийн редакц жилд гадаадаас 4-5 мянган сонсогчийн захидал хүлээж авна. Түүгээрээ “Сонсогч таны хүсэлтээр” гэсэн нэвтрүүлэг явуулдаг. Япон хэлний нэвтрүүлгийг Монголын радиод бэлтгээд бичлэгийг Японы үндэсний радиогоор Токио хотоос дамжуулан Япон орон даяар хүргэдэг аж. Тэгэхдээ Улаанбаатарт Монголын радиод бэлтгэсэн хөтөлбөрөө богино долгионоор япон тийш чиглэлийн антенаар бас цацдаг. Гадаад нэвтрүүлэг юуны өмнө монгол орны улс төр, эдийн засаг, соёл урлаг, зан заншил, монгол дэлхий

дахинд, дэлхий монгол дахинд гэсэн нэвтрүүлэг бэлтгэж явуулдаг. Амралтын өдрөөр “Ням гарагийн уран зохиол” гэсэн хөтөлбөр мөн Монголын эстрад, рок, поп хөгжим, ардын дуу зэрэг холимог хөтөлбөр бэлтгэж ням гарагт эфирт гаргана. Мөн монгол орны байгалийн байдал, ан амьтан, хөдөөгийн ард түмний амьдрал ахуй зэргийг хөтөлбөрийн нэг тогтмол булан болгон явуулдаг. Өнөөгийн байдлаар дэлхийн 40 гаруй орноос 3 мянга гаруй сонсогч байнга захидал бичиж байна. Тус радиогийн байнгын сонсогчид Японы Осака, Энэтхэгийн Дели, Хятадын Тяньжин хотод сонсогчдын клуб байгуулан нэвтрүүлгийн сонсолт ямар байгаагаас эхлээд ямар сэдэв хамгийн их сонирхол татаж байгааг байнга мэдээлж байна. Мөн одоогоор “Монголын дуу хоолой” радио станц 19 хүний бүрэлдэхүүнтэй ажиллаж байгаа бөгөөд 3-4 хүний бүрэлдэхүүнтэй таван хэлний редакц үйл ажиллагаагаа явуулж байна. Интернет хэрэглээний энэхүү эринд “Монголын дуу хоолой” радио “vom.mn” сайтаа нээж түүгээрээ мэдээлэл дамжуулж, радио нэвтрүүлгээ цацдаг болсон нь нэгэн жишээ юм. “Монголын дуу хоолой” радио станц нь өдөрт 30 минутын турш хоёр удаагийн давталттайгаар, долоо хоногт 400 гаруй минутын турш нэвтрүүлгүүдээ хүргэдэг. Нэг удаагийн 30 минутын дугаарын 30%-ийг дуу хөгжим, 40%-ийг нэвтрүүлэг, 30%-ийг мэдээллийн хөтөлбөр эзэлдэг.

Нэвтрүүлгүүдийг өдөр, өдрөөр нь задалбал:

- Даваа гаригт: 1.Мэдээллийн хөтөлбөр, 2.Дууны нэвтрүүлэг
- Мягмар гаригт: 1.Мэдээллийн хөтөлбөр, 2.Шуудангийн хайрцаг, 3. Захидлаас үүдсэн сэдэв

- Лхагва гаригт: 1.Мэдээллийн хөтөлбөр, 2.Монголын уламжлалт хоол, 3.Монгол аялал
- Пүрэв гаригт: 1.Мэдээллийн хөтөлбөр, 2.Соён гэгээрүүлэгч, 3.Шуудангийн хайрцаг
- Баасан гаригт: 1.Мэдээллийн хөтөлбөр, 2.Дуу хөгжмийн нэвтрүүлэг
- Бямба гаригт: 1.Мэдээллийн хөтөлбөр, 2.Соён гэгээрүүлэгч
- Ням гаригт долоо хоногийн нэвтрүүлгийн давталтыг сонсогчдод хүргэдэг байна.

“Монголын дуу хоолой радио” радио станцын эдгээр нэвтрүүлгийн сэдэв, агуулга нь бүхэлдээ Монгол соёл, ахуй, зан заншлыг гадаадын сонсогчдод таниулахад чиглэсэн байдаг. Жишээ нь, “Монголд үйлдвэрлэв” нэвтрүүлгээр Монгол Улсад үйлдвэрлэгддэг бараа бүтээгдэхүүн болон монгол шинэ брэндүүдийг олон орны сонсогчдод таван орны хэлээр таниулан сурталчилдаг онцлогтой. Тэгэхдээ бүтээгдэхүүний үүсэл гарал, бүтээгдэхүүн үйлдвэрлэгчтэй уулзаж бүтээгдэхүүний

онцлог чанарын талаар сурвалжилга, сурвал-жилсан тэмдэглэл бэлтгэдэг байна. Нэвтрүүлэг долоо хоног бүрийн пүрэв гаригт 15 минутын турш хоёр удаагийн давталттайгаар сонсогчдод хүрдэг байна.

“Монголын дуу хоолой” радиогоор дамжуулдаг мэдээний хөтөлбөр онцлогтой. Олон орны сонсогчдод хүрч монгол орны таниулан мэдээлэх радиогийн ерөнхий зорилгынхоо хүрээнд мэдээ, мэдээллээ зориулан бэлтгэдэг. Өдөр бүр 4-6 мэдээг сонсогчдод хүргэдэг. Мэдээнүүдийн гол шинж нь Монголтой холбоотой гадаад мэдээнүүд зонхилдог. Тухайлбал, Монголын улс төрчдийн гадаадад очсон айлчлал, монгол хүмүүсийн гадаадад оролцож буй тэмцээн, уралдаан, мөн бусад улс

орноос монголчуудтай холбоотой зүйлс гэх мэт. “Монголын дуу хоолой” радио станцын өөр нэг чухал нэвтрүүлэг бол

“Шуу-дангийн хайрцаг” юм. Гадаадын сонсогчид “Монголын дуу хоолой” радиог сонсоод өөрт төрсөн сэтгэгдэл, асууж мэдэхийг хүссэн зүйлс, заримдаа дараагийн нэвтрүүлгээр юуны талаар сон-сох хүсэлтэй байгаа-гаа

илэрхийлсэн захидал ирүүлдэг. “Монголын дуу хоолой” радио жилд дунджаар 2000 захидал гадаадын сонсогчдоос хү-

лээн авдаг. Редак-цаас тухай бүрд нь хариу өгч, захидлыг нь радиогоор сонсон, нэвтрүүлгээ ч сонсогчдын захидлаар бэлтгэх тохиол-дол байдаг байна. Өөрөөр хэлбэл, Монголын дуу хоолой радио станц нь сонсогчидтойгоо эргэх холбоо сайтай ажилладаг байна.



1964 оноос хойш тасралтгүй үйл ажиллагаа явуулж байгаа “Монголын дуу хоолой” радио станц нь Монгол Улсыг дэлхийн олон оронд сурталчлах чухал даалгаврыг амжилттай биелүүлсээр байна. Өнөөдрийн байдлаар тус радио станц монгол, англи, орос, хятад, япон хэлээр өдөр тутам хоёр удаа 30 минутын хугацаатай нэвтрүүлэг дамжуулж байна. Цаашид хөтөлбөрийн үргэлжлэх хугацааг нэмэгдүүлэх, нэвтрүүлэг дамжуулдаг гадаад хэлний тоог нэмэж олон улсын радио өргөн нэвтрүүлэгт эзэлж байгаа орон зайгаа тэлэх зүй ёсны шаардлага бий



“Монголын дуу хоолой” радио станцын үйл ажиллагаа, нэвтрүүлэгт ажиглалт хийсний эцэст дараах дүгнэлтийг хийж болохоор байна. 1964 оноос хойш тасралтгүй үйл ажиллагаа явуулж байгаа “Монголын дуу хоолой” радио станц нь Монгол Улсыг дэлхийн олон оронд сурталчлах чухал даалгаврыг амжилттай биелүүлсээр байна. Өнөөдрийн байдлаар тус радио станц монгол, англи, орос, хятад, япон хэлээр өдөр тутам хоёр удаа 30 минутын хугацаатай нэвтрүүлэг дамжуулж байна. Цаашид хөтөлбөрийн үргэлжлэх хугацааг нэмэгдүүлэх, нэвтрүүлэг дамжуулдаг гадаад хэлний тоог нэмж олон улсын радио өргөн нэвтрүүлэгт эзэлж байгаа орон зайгаа тэлэх зүй ёсны шаардлага бий.

Эшлэл

- ¹ Норовсүрэн. Л. Радио сэтгүүл зүйн үндэс. УБ., 2010. х. 9
- ² Зулькафиль.М, Чойсамба.Ч. Сэтгүүл зүйн түүх. УБ 2005. х. 397
- ³ Жаргал.С. Соёлын хөгжилд олон нийтийн мэдээллийн хэрэгслийн гүйцэтгэх үүрэг. УБ., 2002. х.46

- ⁴ Дүгэр. Б. Анхаараарай, Улаанбаатараас ярьж байна. УБ., 1976. х. 65
- ⁵ Норовсүрэн. Л. Монголын сэтгүүл зүйн түүхэн тойм 2-р боть. УБ.,2012. х.11
- ⁶ Мөн тэнд.
- ⁷ Норовсүрэн. Л. Монголын сэтгүүл зүйн түүхэн тойм 2-р боть. УБ., 2012. х.13

Ашигласан бүтээлийн жагсаалт

1. Дүгэр. Б. Анхаараарай, Улаанбаатараас ярьж байна. УБ., 1976.
2. Жаргал. С. Соёлын хөгжилд олон нийтийн мэдээллийн хэрэгслийн гүйцэтгэх үүрэг. УБ., 2002.
3. Норовсүрэн. Л. Радио сэтгүүл зүйн үндэс. УБ., 2010.
4. Норовсүрэн. Л. Монголын сэтгүүл зүйн түүхэн тойм. 2-р боть. УБ., 2012.
5. Зулькафиль. М, Чойсамба.Ч. Сэтгүүл зүйн түүх. УБ., 2005.

Резюме

В статье рассматривается специфика иновещания Монголии. Описывается история и общая характеристика мирового иновещания, анализируется нынешнее состояние радиостанции “Голос Монголии”.